



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 03 сарын 14 өдөр

Дугаар А/133

Хэрлэн сум

“Оюутан цэрэг”-ийн танхим тохижуулахад хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Цэргийн албаны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 85 дугаар тогтоолоор батлагдсан (Оюутан цэрэгт мэргэжил олгох) журам, Монгол Улсын батлан хамгаалах зарим чиг үүргийг Хэнтий аймагт төлөөлөн 2025 онд хэрэгжүүлэх гэрээний 5.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Батлан хамгаалах сайдын 2025 оны А/43 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах, Хэнтий аймгийн Политехникийн коллежоос “Оюутан-цэрэг” хөтөлбөрт хамрагдаж байгаа оюутнуудын суралцах орчин нөхцөлийг сайжруулахад шаардлагатай 6,000,000 (зургаан сая) төгрөгийн хөрөнгийг зарцуулсугай.

2. Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Дээрх үйл ажиллагааны зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Н.Үнэнбат)-д, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (А.Жаргалсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.АЮУРБУНЬ

